

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

/Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

/Б.САНЖИДМАА/

**НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРОО ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН
БЦГ, ЖАРГАЛАНТЫН АР НЭРТЭЙ ГАЗАР БАЙРЛАХ “АЛТАЙ РЕСОУРСЕС”
ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ТЭНГЭР РЕСОРТ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
БААЗ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2790483 /



ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
ЯАМНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГОВЬ ЭКО ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

/Г.БИЛГҮҮНЖАРГАЛ/

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2 Төслийн байршил	5
1.3. Хүчин чадал	6
1.4. Барилга байгууламж	6
1.5. Усан хангамж	7
1.6. Бохир ус	7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	8
Газарзүй	8
Уур амьсгал ба агаар чанар	8
Гадаргын ба газрын доорх ус	9
Хөрсөн бүрхэвч	9
Ургамалан бүрхэвч	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
3.1. Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл	13
3.2. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	13
3.3. Хийн хаягдлын үзүүлэх нөлөөлөл	14
3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл	15
3.5. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	15
3.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	16
3.7. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	17
3.8. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	17
3.9. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл, дүгнэлт	18
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт	19
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	21
4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	23
4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	29
БҮЛЭГ 5. ХАВСРАЛТ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн мэдээлэл	4
Хүснэгт 1.Хаягдал усны шинжилгээний дүн	8
Хүснэгт 2. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчим	11
Хүснэгт 3. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ	14
Хүснэгт 4. Автомашины утааны бүрдэл найрлага	14
Хүснэгт 5. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	14
Хүснэгт 6. Усан орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	15
Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ	16
Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ	16
Хүснэгт 9. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ	17
Хүснэгт 10. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ	18
Хүснэгт 11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл.....	18
Хүснэгт 12. БОМТ-ний зардлын задаргаа /мян.төг/	20
Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	23
Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
Хүснэгт 19. БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө.....	29

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг.....	5
Зураг 2. Төслийн талбайн фото зураг	6
Зураг 3. Төслийн талбайн байршил.....	6

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл


Хүснэгт 1. Төслийн мэдээлэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгч:	“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн дугаар	9011056059
1.3	Регистрийн дугаар	2790483
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1-р 40 мянгат, 100, 521 тоот
1.5	Газар ашиглах гэрчилгээний дугаар	2025 оны 05-р сарын 23-ны өдрийн 00405 тоот гэрчилгээ
1.6	Төслийн талбай	117219.00 м ² буюу 11.8 га талбайтай.
1.7	Харилцах утас:	99082244
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төсөл
2.2	Төслийн зорилго	Гадаад болон дотоодын аялагч амрагч нарт ая тухтай аюулгүй орчинд амрах болон үндэсний өв уламжлалаа суртачлан таниулах, байгалийн үзэсгэлэнт газар, цэвэр агаарт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мөн монгол улсын эдийн засагт өөрийн хувь нэмрээ оруулах эдийн засгийн үр өгөөжийг хүртэхэд төслийн зорилго оршино.
2.3	Төсөл хэрэгжих байршил	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Жаргалантын ам, Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт
2.4	Төслийн хүчин чадал	Шалны халаалттай цомцог гэр 25 ш, зуны жижиг байшин 4 ш, 5 ханатай 00-н тусгаарлалттай шинэ цомцог гэр 16 ш, нэг ээлждээ 140 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай.
2.5	Ажиллах хүч	Нийт 15 ажилтантай.
2.6	Цахилгаан хангамж	Налайх дүүргийн цахилгааны төвлөрсөн сүлжээнээс Тэрэлжийн баруун салаанд байрлах амралт, жуулчны баазууд руу татсан агаарын шугамын дэд станцаас холбон цахилгаанаар ханган ажиллаж байгаа.
2.7	Усан хангамж	107° 24' 10.02" 47° 53' 11.95" байршилд гаргасан өөрийн эзэмшлийн худгаас хангана.
2.8	Хог хаягдал	Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ газартай гэрээ байгуулан тээвэрлүүлдэг.
2.9	Зам харилцаа	Налайх дүүргээс хатуу хучилттай замаар 10 км, 4,5 км орчим шороон замаар холбогдсон Налайх дүүргээс хатуу хучилттай замаар 10 км, 4,5 км орчим шороон замаар холбогдсон.


2.10	Харилцаа холбоо	Skytel, Mobicom, Unitel, Gmobile зэрэг бүх төрлийн үүрэн телефоны сүлжээнд холбогдсон.
2.11	Газарзүйн байршил, координат	107° 24' 23.353" E 47° 53' 10.977" N 107° 24' 18.824" E 47° 53' 7.362" N 107° 24' 16.527" E 47° 53' 9.363" N 107° 24' 6.644" E 47° 53' 7.835" N 107° 23' 58.204" E 47° 53' 17.858" N 107° 24' 9.326" E 47° 53' 20.720" N

1.2 Төслийн байршил

“Алтай ресурсес” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төсөл нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хороонд харьяалах Горхи-Тэрэлжийн Байгалийн Цогцолбор газар, Сэртэнгийн ар нэртэй газрын хязгаарлалтын бүсэд тусгай хамгаалалттай газар нутгийн 117219 м² талбай буюу 11.8 га газар ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршилын зураг



Зураг 2. Төслийн талбайн фото зураг



Зураг 3. Төслийн талбайн байршил

1.3. Хүчин чадал

“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз нь хүчин чадлаа өргөтгөж нэг ээлжиндээ хамгийн их хүчин чадлаараа 140 орчим хүнийг хүлээн авч үйлчлэх бөгөөд нийт 15 ажилтантай.

1.4. Барилга байгууламж

“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төсөл нь төслийн талбайдаа дараах барилга байгууламжуудыг төлөвлөж өгсөн.

- Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй байгууламжууд;
- Шалны халаалттай цомцог гэр 25 ширхэг, зуны жижиг байшин 4 ширхэг, 5 ханатай 00-н тусгаарлалттай шинээр баригдаж буй цомцог гэр 16 ширхэг;

- 100 хүн зэрэг үйлчлүүлэх боломжтой галарей ресторан 1 ширхэг, 40 хүн зэрэг үйлчлүүлэх 8 ханатай монгол гэр ресторан 1 ширхэг;
- Монгол хоол боловсруулалт хийх гэр гал тогоо 1 ширхэг;
- Боловсон ариун цэврийн өрөө эрэгтэй, эмэгтэй тус бүр 5 ширхэг, халуун усны душ эрэгтэй 5, эмэгтэй 9 ширхэг мөн угаалга, хатаалгын газар;
- Од ажиглах болон амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх гадна тавцан террас 1 ширхэг;
- Сагсан бөмбөг, гар бөмбөгийн талбай тус бүр 1 ширхэг, гадаа талбайд суух сүүдрэвч 3 ширхэг;
- Туслах аж ахуй нарийн ногоо тариалдаг хөрсийг нь боловсруулж хашаажуулсан задгай талбай 1 ширхэг мөн жижиг хүлэмж 2 ширхэг, төрөл бүрийн жимс жимсгэнийн болон танин мэдэхүйн зориулалтаар ашиглах 20 гаруй төрлийг нутагшуулж буй нийт 300 гаруй бут бүхий цэцэрлэгт хүрээлэн 1 ширхэг;
- Өндөр хүчдэлийн шугам;
- 1 ш гүний худаг;
- Автомашины зогсоол;
- Ангилсан хог, дахиварын зориулаттай хогийн савнууд г.м

1.5. Усан хангамж

Уг төсөл хэрэгжих байршил нь Туул голын сав газарт хамаарах бөгөөд унд ахуй, ногоон байгууламжийн усны хэрэглээг

Гүний худгийн усны ундарга: 1.2 л/сек

Өдөрт ашиглах усны хэмжээ: 39.4 м³/хон

Усны боломжит нөөц: 123.21 м³/хон бөгөөд төслийн үйл ажиллганд **хүрэлцээтэй** гэж үзэж байна.

“Алтай ресурсес” ХХК-ийн нийслэлийн Налайх дүүргийн Горхи Тэрэлжийн БЦГ-т хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз” төсөлд шаардагдах 39.48 м³/хон усны хэрэглээг 1.2 л/сек (103.7 м³/хон) ундаргатай гүний худгаас, ногоон байгууламжийн усалгаанд цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн 0.22 л/с (19.5 м³/хон) усаар хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

1.6. Бохир ус

Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн бохир усыг төслийн талбайд байрлуулсан бохир ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр 95-98% хүртэл цэвэршүүлж, гарсан саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглана. Төхөөрөмжөөс гарах саарал усыг Стандарт хэмжил зүйн газрын Нийслэлийн салбар Налайх дүүрэг дэх лабораториор шинжлүүлсэн ба шинжилгээний дүнг Монгол улсын стандарт MNS 6734:2018-Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага, болон MNS 4943:2015-Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартуудтай харьцуулахад стандартаас давсан үзүүлэлт байхгүй тул саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж болно гэж үзэж байна.

Хүснэгт 2.Хаягдал усны шинжилгээний дүн

Дээжийн дугаар	№	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний дүн
531	1	ББЕТ	-	16*10 ⁴
	2	Эмгэгтөрөгч нян	1 мл-т илрэхгүй	1 мл-т эмгэгтөрөгч илрээгүй
	3	Гэдэсний бүлгийн савханцрын таныц	-	0,111
	4	Clostridium perfringens	-	0,1
	5	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	20, мгО/л	16,0
	6	Нитрат	<20, мг/л	2,5
	7	pH	6-9	8,22
	8	Сульфат	700, мг/л	92,6
	9	Умбуур бодис	<30, мг/л	28,0
	10	Хлорид	1000, мг/л	95,7
	11	Нитрит	мг/л	0,31
	12	Фосфат	мг/л	1,24
	13	Ууссан хүчилтөрөгчийн агуулга	мг/л	6,7

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Газарзүй

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт нийт 293168.0 га талбайг эзлэн оршдог. Тус цогцолбор газрын нутаг дэвсгэрт Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэг, Хэнтийн тайгын өмнөд хэсгийн ойт хээр бүхий дундаж өндөр уулс хамрагдана.

Тус БЦГ-ын хамгийн хойд цэг нь Хан Хэнтийн ДЦГ болон Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хилийн заагт оршиг Гэл уул (2550.8; х.ө. 480251332, з.у. 1070381348), өмнөд цэг нь нь Гандан уулын ар, Туул голын урд эрэгт орших ба хойноосоо урагш 77 км үргэлжилнэ. Баруун захын цэг нь Дархитын даваанаас баруун хойд зүгт орших 2045.6 тоот өндөрлөг (х.ө. 480121465), зүүн захын цэг нь Юдэгийн (Жүдэгийн) даваа (1985.0; х.ө. 480171747, з.у. 108006169) ба баруунаас зүүн тийш 70 км үргэлжилнэ.

Цогцолборт газрын хамгийн өндөр цэг нь Алтан-Алгий уул (2645.7), хамгийн нам цэг нь Туул голын Бүдүүн чулууны гарам (1376.0) юм.

“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК-ийн ашиглаж буй 11.8 га газар нь тусгай хамгаалалттай газрын кадастртай зөрчилгүй, ой болон усан сангийн хамгаалалтын бүстэй давхцдаггүй.

Уур амьсгал ба агаар чанар

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш хэмийн хуваарилалттай, чийглэг зэврүүн зун, хахир өвөлтөй уур амьсгалын мужид багтах бөгөөд уур амьсгалын нөхцөлийн хувьд чийгийн хангамж 1-ээс их, нэмэх температурын нийлбэр буюу дулаан хангамж нь 15000°C-с их нутаг болно. Жилийн дундаж агаарын температур төв хэсэгтээ -4.0°C-ээс хүйтэн байх боловч газрын гадаргаас ихээхэн шалтгаалж өөр байна. Тухайлбал, Тэрэлж голын сав, Туул

голын явцуу хөндийд $-4-4.2^{\circ}\text{C}$ ба үүнээс ч хүйтэн байдаг. 1-р сарын агаарын дундаж температур $-21,5^{\circ}\text{C}$, голын хөндий дагуу $21.0-23.0^{\circ}\text{C}$, 7-р сарын агаарын дундаж температур уул өөдөө $39,0^{\circ}\text{C}$, голын хөндий болон өвөр ээвэр газар 38.0°C дулаан байна. Ургамал ургах идэвхтэй температур буюу 5.0°C -ээс дулаан үе 126 хоног, 12.94°C байхад зуны ашигтай температур буюу 10.0°C -ээс дулаан 72 хоногт 878°C хуримтлагддаг нь манай орны өндөр уулын бүс нутгийн өвөрмөц онцлог юм.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь хамгийн өндөр чийгшилтэй нутагт тооцогдоно. Жилд унах хур тунадасны нийлбэрийн олон жилийн дундаж 350 орчим мм байхаас 95-97 хувь нь дулааны улиралд унах ба олон жилийн нийлбэрийн дундаж нь 100-120 мм хүрнэ.

Салхины хурд бусад нутгаас бага, жилийн дунджаар 0.9-1.5 м/с байх боловч голын хөндийгөөр 2.5-4.8 м/с хүртэл нэмэгддэг. Агаарын даралт дунджаар 843 гПа байх боловч голын хөндийгөөр 865 гПа (650 мм) хүртэл хэлбэлзэнэ.

Гадаргын ба газрын доорх ус

Тус нутаг нь Туул голын сав газарт хамаарах бөгөөд хаврын шар ус, зуны хур борооны үед түр хугацаанд усжилт нэмэгддэг боловч бусад үед тогтмол урсацтай горхи, булаг цөөн байна. Туул голын урсацын 69%-ийг дулааны улирлын хур тунадас бүрдүүлдэг бөгөөд сав газрын хур тунадас өсөх хандлагатай ч ургамалан бүрхэвч сийрэгжилтээс шалтгаалж гадаргын урсац нэмэгдэж байна.

Газрын доорх усны хувьд нийслэлийн нутаг дэвсгэрийн 64% нь нөөц багатай ангилалд ордог. Туул голын сав газрын Улаанбаатар орчимд газрын доорх усны ашиглалт 44.7%-д хүрч, 2030 он гэхэд усны хэрэглээ хоногт 614.4 мян. м³ болж нэмэгдэхээр байна. Иймд усны нөөцийн хяналт, зохицуулалтыг эрчимжүүлэх шаардлагатай.

Тус сав газарт улсын хүн амын 46.3%, ДНБ-ий 60 гаруй хувь төвлөрдөг тул усны нөөцийн стратегийн ач холбогдол өндөр. Голын татам дахь суурьшил, хотын бохир ус, алт олборлолт зэрэг хүчин зүйлсээс үүдэн Туул голын экологийн доройтол нэмэгдэж, хаврын гачиг үед урсац тасрах үзэгдэл түгээмэл болж байна.

Хөрсөн бүрхэвч

Хотын төвийн хөрсөн бүрхэвч ноцтой муудаж, үржил шимт чанараа бүрэн алдсан байна. Гэр хороололд хөрсний эвдрэлээс шалтгаалан хөрсний үржил шимт давхраа арилж хайрга, чулуулгийг хамарсан, хөрсний доод давхраа ил гарсан байдаг. Сүүлийн жилүүдэд хөрсний ийм эвдрэл улам нэмэгдэж байгаа тухай мэдээлж байгаа бөгөөд 2003- 2007 оны хооронд хөрсөн доторх хүнд металлын бохирдлын түвшин нь зөвшөөрөгдөх түвшнээс байнга хэтэрч байсан байна.

Төслийн үйл ажиллагааны туршид барилгын талбай дагуу хөрс, ургамалан бүрхэвч доройтолд орж эвдэрнэ.

Хөрсний агрохимийн задлан шинжилгээнээс харвал “АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК-ний эзэмшил газрын хөрсний урвалын орчин шүлтлэг, ялзмагийн агууламж 2-3.21 хувьтай хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд зэрэг. Хөрсний хөдөлгөөнт фосфорын пентоксидын хангамж дээж авсан цэгүүдийн дээд үе давхаргад 2.9-4.1 мг/100 гр буюу бага зэргийн хангамжтай байна. Калийн исэлийн хангамж хөрсний цэгүүдийн дээд үе давхаргад

21-26 мг/100 гр буюу сайн хангамжтай байна. Хөрсний рН-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Урвалын орчин 6.71-6.73 буюу дунд зэрэг шүлтлэг байна. Мөн хөрсний ерөнхий судалгааны үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Суурин газрын цэгүүдийн өнгөн (0-10 см) хөрсөн дэх давсжилт 0.06-0.08 dS/m хооронд буюу бага зэргийн давсархаг байна.

Ургамалан бүрхэвч

Улаанбаатар хот нь Хэнтийн уулын тайгын тойрог болон Монгол дагуурын уулын ойт хээрийн тойргийн заагт орших ба уулс-хөндийн зохилдлоготой тогтоц бүхий дундаж, нам уулсын бүсэд багтана. Хотын нутаг дэвсгэр дэх ургамалжилт нь газрын гадарга, өндөршил, бичил уур амьсгалын нөхцөлөөс хамааран өндөр уулын, ойт хээрийн, уулын нугархаг хээрийн болон тал хөндийн хэв шинжүүдэд хуваагддаг.

Туул голын дагууд ледебурын бургас, улиас, монос, өрөл, долоогоно, улаалзгана болон бусад жимст бутлаг ургамлууд зонхилон тархсан бөгөөд хотын ногоон бүсэд нийт 4443 га бургасан шугуй, 549 га улиасан шугуй бүрдэж байна. Хээр бүсэд хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар, дааган сүүл, агь, шарилж зэрэг зонхилогч ургамал бүрэлдэнэ.

Судалгаанд хамрагдсан Налайх дүүргийн 6-р хорооны “Тэнгэр ресорт” төслийн талбай нь “Хялгана, хиаг, таван салаа, навтуул гичгэнэ, ишгэн шарилж” болон “Ботуулийн-алаг өвстэй” шинэсэн болон шинэс-хусан ойн ургамлын бүлгэмдлийн хэв шинжид багтах бөгөөд ургамлан бүрхэц 70–85 хувьтай байна. Талбайд зонхилох ургамалд Хялгана, хиаг, таван салаа, навтуул гичгэнэ, ишгэн шарилж зэрэг ургамал багтана.

Судалгааны арга зүйд Л.Г. Раменскийн 1 м² торон трансектийн аргыг ашиглан ургамлын бүрхэц, халцгай газар, хад чулуу, хагдны эзлэх хувийг тодорхойлсон. Зүйлийн арвийг Друдегийн үнэлгээний шатлалын дагуу талбайд эзлэх харьцаагаар тооцож үнэлсэн. Судалгааны талбайд нийт 15 нэр төрлийн ургамал бүртгэгдсэн ба эдгээрийн ихэнх нь биелэгтэн болон гол гэсэртэн овгийн төлөөлөгчид байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Алтай ресоурсес” ХХК-ийн “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо судалгааны материалуудыг үндэслэн магадлан жагсаах аргаар тодорхойлсон болно. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Аливаа төслийг хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ аргаар тухайн төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хийхдээ экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар гүйцэтгэв. Тус аргыг ашиглах үед экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлт оролтын мэдээ болох бөгөөд үр дүнд төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно. Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, хүрээлэн буй орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5 үндсэн бүлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Эрчим			
		Нөлөөлөлтэй эсэх, +,-, 0	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт	0									
2	Газрын доорх усны чанарт өөрчлөлт	-		-		-					-
3	Гадаргын усны өөрчлөлт	0									
4	Агаарын чанарын өөрчлөлт	-	-			-				-	
5	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-	-			-					-
6	Хөрсний элэгдэл, эвдрэл	-	-				-			-	
7	Геологийн тогтцын өөрчлөлт	0									
8	Зэрлэг амьтдын орон зай	0									
9	Уур амьсгалын бичил өөрчлөлт	0									
Байгалийн нөөц ашиглалт											
10	Гадаргын нөөц баялаг	-				-					-
11	Бэлчээрийн байдал	0									
12	Эрдэс түүхий эдийн нөөц	0									
13	Эрчим хүчний нөөц	-				-					-
Байгаль орчны өөрчлөлт											
14	Ундны усны чанар, хэмжээ	0									
15	Урсгал усны хэрэгцээ	0									
16	Агаарын бохирдол	-	-			-				-	
17	Хөрсний эвдрэл бохирдол	-	-				-				-

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
18	Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	0								
19	Ландшафтийн хэлбэр, өнгө өөрчлөгдөх	0								
20	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	-								
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0								
22	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0								
Эдийн засаг, нийгмийн асуудал										
23	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+	+			+			+	
24	Орон нутгийн орлого нэмэгдэх	+	+			+			+	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+	+				+		+	
26	Ажлын байр нэмэгдэх	+	+				+		+	
27	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+	+				+		+	
28	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-		-					-	
Нөлөөлөлгүй		9								
Сөрөг нөлөөтэй		-9	-7	-2	-1	-6	-2		-4	-5
Эерэг нөлөөтэй		+5	+5			+2	+5		+1	+4

Хүснэгтийн тайлбар: /+/-эерэг нөлөөтэй, /-/-сөрөг нөлөөтэй, /0/-нөлөөлөл байхгүй

- **Шууд нөлөөлөл:** Болзошгүй нөлөөллийн ихэнх нь хамрагдах бөгөөд үүний улмаас төсөл хэрэгжих орчны байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа хөрс эвдрэх, хөрсний ус бохирдох, ургамлын нөмрөг сүйдэх, салаа зам олшрох, хатуу хог хаягдал цуглуулах савыг ил задгай байлгах, эдгээрийг тогтмол зайлуулахгүй байх болон шингэн хаягдлын шугам хоолой, түүний нэгдсэн системд гэмтэл гарах зэргээр тохиромжгүй байдал (үнэр) үүсэх, явган зам жим олшрох зэрэг хамрагдана.
- **Богино хугацааны нөлөөлөл:** Хог хаягдал зайлуулалд, ариутгал цэвэрлэгээ, хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дуу шуугиан ихсэх, авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох зэрэг хамрагдаж байна.
- **Урт хугацааны нөлөөлөл:** Аялал жуулчлалын төслийн бүтээн байгуулалт, барилга байгууламжийн ажил болон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсний дагтаршил, элэгдэл, эвдрэл, бохирдол, хөрсний усны бохирдол, ой хээрийн түймэр зэрэг багтах бөгөөд эдгээр нь эргэж сэргээгдэхдээ удаан хугацаа шаардана.
- **Буцаж нөлөөлөх нөлөөлөл:** Ахуйн хог хаягдалд зохих ариутгал хийгээгүй, хугацаанд нь зайлуулаагүй зэрэг тохиолдлоос шалтгаалж ялзарч өмхийрөн улмаар элдэв төрлийн халдварт өвчин гарч болзошгүй тохиолдлыг авч үзэж байна. Иймээс аливаа ариутгал цэвэрлэгээг энэ орчинд тухай бүрд нь хийж байхгүй бол ахуйн хатуу, шингэн хаягдал ихээр бохирдсоноос буцаж нөлөөлөх магадлалтай.
- **Буцалтгүй нөлөөлөл:** Байгаль орчинтой холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзэж буй тул авто тээврийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болохоос бусад нь хамрагдаж байна.

- **Өөрөө зохицуулагдах нөлөөлөл:** Авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох болзошгүй нөлөөллийг авч үзсэн бөгөөд, энэ нь нэгд үргэлжлэх хугацаа богино, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтаас гарах хорт хий болон авто тээврийн хэрэгслийн бензин шатахууны угаар хамрагдана.
- **Хүчтэй нөлөөлөл:** Байгалийн гэнэтийн болзошгүй осолд тооцогддог нөлөөллүүд болох газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, анхаарал болгоомжгүйн улмаас гардаг ой, хээрийн түймэр орох бөгөөд энэхүү нөлөөлөлд нэрвэгдсэн байгаль орчин нь нөхөн сэргээгдэхдээ удаан хугацаа шаардахын зэрэгцээгээр байгаль орчныг хамгаалах урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулна.
- **Дунд зэргийн нөлөөлөл:** Хөрс, хөрсний усанд бохирдуулагч бодис нэвчих, хүн ам, авто тээврийн хэрэгслийн тоо ихэссэнээс ургамал нөмрөг талхлагдах, хог хаягдлыг ариутгах, зөөж тээвэрлэх ажил удаашрах зэрэг зүйлүүд орно.
- **Бага нөлөөлөл:** Төслийн ойр орчимд амрагчид зохион байгуулалтгүй аялах зугаалах боломж гаргах, хөдөлгөөн, чимээ шуугиан ихсэх гэх мэт зүйлүүд орно. Энэ бүхэн нь болзошгүй нөлөөллийн хэлбэр, хугацаа, хүчийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах арга, зөвлөмжид юуг илүүтэй анхаарах боломж олгож байгаа юм.
- Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөллийн тухай: Төсөл нь тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалтын бүсэд хэрэгжиж байгаа боловч газар ашиглалтын зөвшөөрөлтэй, кадастрын зөрчилгүй, ой болон усан сангийн хамгаалалтын бүстэй давхцаагүй тул шууд хориглосон бүсэд нөлөөлөл үүсгэхгүй гэж үнэлсэн. Гэсэн хэдий ч үйл ажиллагааны явцад хөрс, ургамлан нөмрөг, хог хаягдлын менежмент, авто тээврийн хөдөлгөөнд байнгын хяналт тавих шаардлагатай.

3.1. Газрын гадаргад үзүүлэх нөлөөлөл

- Төслийн талбай орчмын газрын хөрс, амралт жуулчны баазын барилгын үе шатанд машин техникийн нөлөөгөөр талхлагдан эвдрэх
- Жуулчдын байр болон орчны бүсүүдэд хөрс ахуйн хатуу хог хаягдал болон органик бодисоор бохирдох
- Автомашины зогсоол түүний орчимд тээврийн хэрэгслээс шатах тослох материалын асгаралт үүсэж хөрс тос, тосолгооны материалаар бохирдож болзошгүй.

3.2. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Тус төсөл хэрэгжих талбай нь суурьшлын бүсээс зайдуу байрлах учир энд агаар цэвэр юм. Төслөөс агаарын бохирдол үүсгэх эх үүсвэр нь барилга байгуулалтын явцад үүсэх тоосжилт, машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох зэрэг болно. Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга юм. Гэвч шороон шуурга нь тухайн үзэгдэлт үед л агаарыг тоосонцороор бохирдуулах боловч байнгын сөрөг нөлөөлөлгүй байна.

Цаашид төслийн үйл ажиллагааны явцад ирж очих амрагчдын машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэр нь дараах байдлаар илэрч болно. Үүнд:

- Ургамлын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд эвдэрсэн газрыг тухай бүрт нөхөн сэргээх, аль болох олон салаа зам гаргахгүй байх, тээврийн хэрэгсэл ирж очих гол замыг сайжруулах, услаж чийглэг болгох зэрэг арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

3.3. Хийн хаягдлын үзүүлэх нөлөөлөл

Автомашинны утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310 г, дизель хөдөлгүүр 80-100 г хорт бодис ялгаруулдаг ажээ. 1 кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин $q=0.725$, дизель $q=0.825$) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашинны утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо, бензиний хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агуулалтыг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агуулалтыг үндсэн үзүүлэлт болгодог.

Хүснэгт 4. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош)
CO (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
HC, C ₆ H ₁₄ (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO _x (ppm)	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулсан ба энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингын хяналтын үзүүлэлт болон ашиглагдах ач холбогдолтой юм.

Хүснэгт 5. Автомашинны утааны бүрдэл найрлага

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	Хоргүй
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	Хоргүй
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	Хоргүй
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	Хоргүй
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	Хортой
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	Хортой
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	Хортой
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	Хортой
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	Хортой
10	Хөө тортог (г/м ³)	0-0.44	0.01-1.1	Хортой
11	Бенз (а) пирен (г/м ³)	<0.00002	<0.00001	Хортой

1 л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн энэ хэмжээ ерөнхийдөө 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

Хүснэгт 6. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт			
----------------------------	--	--	--

Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	Нөлөөллийн түвшин
Тоосжилт	Барилгын үе шатанд	-1	1	1	2	1	2	1	8	Бага
	Автомашин амрагчдын хөдөлгөөнөөс үүдэлтэй	-1	1	1	2	1	2	1	8	Бага
Дуу шуугиан	Амрагчид, автомашины дуу чимээ	-1	1	1	2	1	1	1	7	Бага
Үнэр	Хог хаягдал	-1	1	1	2	1	1	1	7	Бага
Дүгнэлт		Төслөөс агаарын чанарт сөрөг бага зэргийн нөлөөтэй байна.								

3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл бага. Төслийн хэмжээнд шаардагдах усны хэрэгцээг 1 гүний худгаас хангадаг хэдий ч баазын усны хэрэглээнд хүрэлцээтэй гэж үзсэн бөгөөд урт хугацааны явцад усны нөөцөд нөлөөлж болзошгүй. Мөн хүний анхаарал болгоомжгүй үйл ажиллагаа, зүй зохисгүй ашиглалт, хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяж асгах, тээврийн хэрэгслийн шатах тослох материалын асгаралт зэргээс гүний усанд сөрөг нөлөөлөл учирч болзошгүй.

Хүснэгт 7. Усан орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
Газрын доорх усны нөөц баялаг	Үйл ажиллагаанд шаардагдах усны хэрэгцээ	-1	1	2	2	2	2	3	12	Дунд
	Удаан хугацаанд ус татах нь гүний усны түвшингийн бууралт	-1	1	2	2	2	2	3	12	Дунд
Гадаргын усны нөөц баялаг	Төслийн ойр орчимд гадаргын ус байхгүй	0	1	1	1	1	1	1	6	Нөлөөгүй
Усны чанар	Хог хаягдлын зохисгүй менежментээс үүдэн хөрсөөр дамжин гүний ус бохирдож болзошгүй	-1	2	2	2	1	2	1	10	Дунд
Дүгнэлт		Төслөөс усан орчинд сөрөг дунд зэргийн нөлөөтэй байна.								

3.5. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

- Төслийн явцад газрын хэвлий гүн эвдрэлд орохгүй бөгөөд гадаргын хэлбэрт дунд зэрэг өөрчлөлт орно. Төслийн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон талбайг тохижуулж зүлэгжүүлэн ногоон байгууламж байгуулсан тохиолдолд сөрөг нөлөөлөл буурна.
- Амрагчдын автомашин, явган аялал зэргээс олон салаа зам үүсч хөрсөн бүрхэвч дагтаршиж элэгдэл эвдрэлд орно.

- Ахуйн зориулалттай хогийг тогтмол ачуулж ариутгаж цэвэрлэж байгаагүйгээс үүдэн хөрс бохирдож болзошгүй.
- Автомашинаас шатлах тослох материал алдагдсанаар хөрсний шинж чанар өөрчлөгдөж бохирдох

Хүснэгт 8. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
Сөрөг нөлөөлөл	Бүтээн байгуулалтын үед хөрс эвдрэлд орох, шимт хөрс хуулагдах	-1	1	1	2	1	1	1	7	Бага
	Төслийн үйл ажиллагаа, хөл хөдөлгөөн ихэссэнээр хөрс доройтох	-1	1	1	2	1	2	1	8	Бага
	Төслийн үйл ажиллагааны үед гарах хог хаягдлыг тухай бүр ачуулаагүйгээс үүдэн хөрс бохирдох, эвдрэлд өртөх	-1	1	1	2	1	2	1	8	Бага
Дүгнэлт		Хөрсөн бүрхэвчид сөрөг бага зэргийн нөлөөтэй байна.								

3.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбайд ховор болон нэн ховор ургамлын зүйл тэмдэглэгдээгүй. Судалгааны дүнгээр төслийн талбай орчмын ургамлан бүрхэц 70–85 хувьтай, нийт 15 нэр төрлийн ургамал бүртгэгдсэн байна. Харин барилга байгууламж, зам талбай, тохижилт хийгдсэн хэсэгт ургамлан бүрхэвч тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, зарим хэсэгт унаган төрх алдагдсан байна. Иймд цаашид үйл ажиллагааны явцад ургамлан нөмрөгийн талхагдал, тоосжилт, олон салаа зам үүсэхээс сэргийлж, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй байна. Үүнд:

- Төслийн түүхий эдийг тээвэрлэх, ачиж буулгах үед ургамлан нөмрөгийг эвдрэл гэмтэлд оруулах, тоосжилтоос үүдэн ургамлын ургалт буурах
- Явган хүний болон авто машины зам талбайг засаж тохижуулах, тэмдэгжүүлээгүй зэрэг байдлаас үүдэн ургамлан нөмрөг талхагдалд өртөх
- Төслийн үйл ажиллагаанаас авто машины хөдөлгөөний улмаас үүсэх тоосжилт нь талбайн гадна, доторх ургамлан нөмрөгт нөлөөлөх
- Хатуу хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяхгүйн улмаас ургамлан нөмрөгийн үхжилтийг бий болгох
- Олон салаа зам гаргаснаар ургамлан нөмрөгийг талхагдалд оруулах

Хүснэгт 9. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
Ургамалжилт устгах	Аялал жуулчлалын бааз, түүнийг дагалдан бий болох бусад жижиг	-1	1	2	2	1	1	2	10	Дунд

	барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс									
Ургамлын ургах чадварыг алдагдуулах	Машин техникийн хөдөлгөөн, хог хаягдал ба шороо, тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдах	-1	2	2	2	1	1	2	10	Дунд
Дүгнэлт		Төслөөс ургамлан нөмрөгт сөрөг дунд зэргийн нөлөөтэй байна.								

3.7. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үед машин, техникийн нөлөөгөөр үүсэх дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан тухайн орчны амьтад үргэн дайжиж, амьтадын орон зайн өөрчлөлт бий болох, дараа нь үйл ажиллагааны явцад хатуу хог хаягдал болон шингэн хаягдлыг зөв байршуулаагүй дүүрсэн тохиолдолд зайлуулахгүй удаах зэргээс болж орчны хөрс бохирдож улмаар хөрсний бичил организмууд хордох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Хүснэгт 10. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
		H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
Зарим амьтдын амьдрах орчин алдагдах	Бүтээн байгуулалтын үед мөлхөгч, мэрэгчдийн амьдрах орчныг сүйтгэх	-1	1	1	2	2	1	1	8	Бага
Амьтдын тархалт хөдөлгөөн өөрчлөгдөх	Амрагч, автомашины хөдөлгөөн дуу чимээнээс үүдэн амьтад үргэн дайжих	-1	1	1	2	2	1	1	8	Бага
Дүгнэлт		Төслөөс амьтны аймагт сөрөг бага зэргийн нөлөөтэй байна.								

3.8. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл Төслийн хэрэгжилтийн үед нийгэм-эдийн засгийн хөгжилд дараах чиглэлээр эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой юм.

Төслийн хэрэгжилтийн үед төлөгдөх татварыг улс орны төсөвт хуримтлуулах замаар эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх: Төслийн хэрэгжилтийн үед ашгийн татвар, улмаар ажилчин, албан хаагчдын НДШ, ЭМДШ, орлогын албан татвар зэрэг МУ-ын үндсэн хууль болон бусад холбогдох хууль дүрэмд тусгагдсан татваруудыг төлөх замаар улс орны төсөвт хувь нэмэр оруулах боломжтой юм.

Ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах замаар амьжиргааны түвшин, нийгэм-эдийн засгийн салбарт дэмжлэг үзүүлэх:

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулна.

Хүснэгт 11. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
	H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C	Σ	
Төслийн хэрэгжилтийн үед төлөгдөх татварыг улс орны төсөвт хуримтлуулах замаар эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх	+1	2	2	2	2	3	3	14	Дунд
Ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах замаар амьжиргааны түвшин, нийгэм-эдийн засгийн салбарт дэмжлэг үзүүлэх	+1	2	2	2	2	2	3	13	Дунд
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулах	+1	2	2	2	2	2	3	13	Дунд
Дүгнэлт	Төслөөс нийгэм эдийн засагт эерэг дунд зэргийн нөлөөтэй байна.								

3.9. Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл, дүгнэлт

“Алтай ресурсес” ХХК-ийн Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох агаарын чанар, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, нөлөөллийн эрчим, цар хүрээг суурь судалгаа болон хээрийн судалгааны хэмжилтийн мэдээ, лабораторийн дээж шинжилгээнд үндэслэн тодорхойлсныг нэгтгэн доор хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл

Байгаль орчин	Эерэг нөлөөлөл			Сөрөг нөлөөлөл		
	Бага	Дунд	Их	Бага	Дунд	Их
Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	4	-	-

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл	-	-	-	1	3	-
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	-	-	-	3	-	-
Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	-	2	-
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	-	-	-	2	-	-
Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	-	3	-	-	-	-
Нийт	0	3	0	10	5	0

Дүгнэлт: Хүснэгтийн тоон үнэлгээний үр дүнгээс харахад сөрөг нөлөөллийн нийт 15 үзүүлэлтээс 10 нь бага, 5 нь дунд түвшний ангилалд хамаарч байна. Үүнийг хувиар илэрхийлбэл сөрөг нөлөөллийн 66.7% нь бага, 33.3% нь дунд ангилалд багтаж байгаа бөгөөд дунд түвшний сөрөг нөлөөлөл нь усан орчин болон ургамлан нөмрөгтэй холбоотой байгаа тул эдгээр чиглэлд хяналт, бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай. Иймд төлөвлөсөн менежментийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн байгаль орчинд үзүүлэх нийт сөрөг нөлөөллийг “БАГА” гэж үнэлэгдэв.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт.

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Тэнгэр ресорт” аялал жуулчлалын бааз төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч төслийн хэрэгжүүлэх нийт хугацаанд энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Төслийн 2026 оны БОМТ-г боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтын аялал жуулчлалын төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгын хүрээнд боловсруулав. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид болон оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө тусгагдсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд нийт **17,600.0 мян.төг** зарцуулахаар төлөвлөв.

Төслийн талбайд түүх, соёлын үл хөдлөх дурсгал, археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй тул тусгайлсан зардал төлөвлөөгүй. Гэхдээ төслийн үйл ажиллагааны явцад санамсаргүй байдлаар түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд тухайн хэсгийн ажлыг нэн даруй зогсоож, холбогдох мэргэжлийн байгууллага болон эрх бүхий байгууллагад мэдэгдэн, хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын арга хэмжээ авч ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хураангуйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 13. БОМТ-ний зардлын задаргаа /мян.төг/

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,900.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3,920.0
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4,080.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,500.0
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,200.0
6	ЖИЛИЙН ЗАРДАЛ	17,600.0

Төсөл нь Налайх дүүргийн 6-р хороонд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт хязгаарлалтын бүсэд хэрэгжиж байгаа тул үйл ажиллагааг зөвхөн газар ашиглах эрхийн хүрээнд, батлагдсан зориулалт, хүчин чадал, талбайн хил заагийн дотор явуулна. Төслийн үйл ажиллагааны явцад газар ашиглалтын хил заагийг тэлэх, олон салаа зам үүсгэх, ургамлан нөмрөг талхлах, хог хаягдал ил задгай хуримтлуулах, бохир ус болон шатах тослох материал хөрсөнд нэвчихээс урьдчилан сэргийлэх хяналтыг тогтмол хэрэгжүүлнэ.

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 14. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5		6	7	8
АГААР ОРЧИН								
CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасах	Авто машин болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утааны бохирдуулагч зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зориулалтын шүүлтүүр тавих, солих	Төслийн хүрээнд хэрэглэгдэх авто тээврийн хэрэгсэлд	-	150.0	-	150.0	2026 оны 9-р сард	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын бохирдол үүсэх	Барилгын үеийн болон ахуйн хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Төслийн талбайд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан					Хог хаягдлын тухай хууль
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ								
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн	Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, /төслийн	Төслийн талбайд	ш	150.0	-	150.0	2026 оны 7 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 8.1.4, 9.1.1

талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө. Барилгын ажлын улмаас хаягдлаар хөрс бохирдож болзошгүй	хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх/							- Газрын тухай хуулийн 26,27,57 дугаар зүйл - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль - MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
	Амралтын газрын үйл ажиллагааг илэрхийлсэн нэр хаяг бүхий самбар, ногоон байгууламж, явган хүний зам, олон нийтийн амралт, тоглоомын талбай, тээврийн зогсоол зэрэг нь тэмдэг тэмдэглэгээтэй байна.	Төслийн талбайд	ш	300.0	1	300.0	2026 оны 7 сард	
	Ашигт ургамлын байршлыг тэмдэгжүүлж хамгаалалтад авах	Төслийн хариуцан хамгаалах талбай		200.0		200.0	2026 оны 10-р сард	
Мэрэгчид, мөлхөгчид болон сээр нуруугүйтэн амьтдын амьдрах орчныг сүйтгэх	Төсөл хэрэгжих нутгийн амьтны аймгийн төрөл зүйл, тархалт, тоо толгойн талаарх судалгаа хийж судалгааны материал, мэдээллийн сан үүсгэх	Төслийн талбай орчимд	1000.0				Төсөл хэрэгжих хугацаанд	Амьтны тухай хууль
УСНЫ НӨӨЦ, ЧАНАР								
Усны чанарт нөлөөлөх буюу санаандгүй байдлаар шатах	Бохир усны шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг хангах шалгах	Төслийн талбайд	Удаа/жил	50.0	2	100.0	Жилд 2 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 18.1-18.2

тослох материал, химийн бодис алдах								Усны тухай хуулийн 19-р зүйл
НИЙТ ЗАРДАЛ /МЯН.ТӨГ/							1,900.0	

4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3			4	5	6	7
Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих цэцэрлэгжүүлэх зүлэгжүүлэх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод, бут тарих, арчлах	Эзэмшил газрын 20% буюу 0.3 га талбайд	ш	20 ш мод 20 ш сөөг	1800.0		2026 оны 5,10 сард	- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5918 : 2023 - Мод, сөөгний суулгац арчлах MNS6258-2:2011
	Харьяа дүүрэг, захиргаатай хамтран ажиллах				200.0		2026 оны 10 сард	

	Ногоон байгууламжын усалгаа, тордолт, тайралт, хэлбэржүүлэлт хийх /Дулааны 6 сар, сард 4 удаа	Төслийн талбайд		80.0*4*6=1920.0	2026 он	
НИЙТ ЗАРДАЛ /МЯН.ТОГ/				3,920.0		

4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, ослын сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Гал түймрийн аюул, осол	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчидад	-	100.0	100.0	2026 оны 5 сард	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS 5390:2004, “ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
	Объектын дотор талбайд хамаарч галын хор, элс байршуулах	Төслийн талбай		800.0		2026 оны 10 сард	
Гамшиг, осол	Төслийн үйл ажиллагааны явцад галын аюул, гамшгийн эрсдэлийн	Төсөлд		3000.0		2026 оны 10 сард	Гамшгаас хамгаалах тухай хууль,

	үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх				-MNS 5247:2003 Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн цогцолбор
Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг суурилуулах	Төслийн талбай орчимд	80.0	2026 оны 7 сард	
Газар хөдлөлт	Ажилчдыг газар хөдлөлтийн үеийн сургалтанд хамруулах	Ажилчдад	100.0	2026 оны 9 сард	
НИЙТ ЗАРДАЛ / МЯН.ТӨГ/			4,080.0		

4.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Хатуу хог хаягдал	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх.	Хог хаягдлын цэгт	гэрээ	80	5	400.0	Сард 1 удаа /5-9-р саруудад/	Хог хаягдлын тухай хууль, MNS 5344:2011
	Хог хаягдлыг тогтмол хугацаанд төслийн талбайгаас зайлуулж байх.	Төслийн талбай	удаа	300.0	12	3,600.0	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, UCS 1705A:2022
	Нийтийн эзэмшлийн талбай, хогийн сав байршуулах.	Төслийн талбай	ширхэг	100.0	5	5,00.0	2026 оны 4 сард	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,

								тээвэрлэх ерөнхий шаардлага
НИЙТ ЗАРДАЛ / МЯН.ТӨГ/						4,500.0		

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7
Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд 1 цэгт	Агаарын найрлага: жилд 4 удаа /2, 4, 8, 11 саруудад/	4	200.0	800.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ; MNS 3113:1981 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага
Хөрсний чанар /агрохими, эрүүл ахуй, хүнд металл/	Төслийн талбай орчим болон хог хаягдлын цэгийн орчимд 2 цэгт.	Жилд 2 удаа 2 цэгт	2	200.0	800.0	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага; MNS 3310:1991 Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга; MNS 6824:2020 Пирофосфат натри ашиглан хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох арга;

						MNS 3297:2019 Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт; MNS 5367:2004 E.coli илрүүлэх арга; MNS 5850:2019 Хөрсний чанар. Бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ундны усны чанар /ерөнхий хими, хүнд металл, микробиологи/	Гүний худаг	Улирал бүр	4	200.0	800.0	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ; MNS ISO 5667 Усны чанар. Дээж авах аргачлал; MNS ISO 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
Хаягдал усны шинжилгээ	Бохир ус цэвэрлэх байгууламжийн гаралтын хэсэг	Улирал бүр	4	200.0	800.0	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
НИЙТ ЗАРДАЛ /МЯН.ТӨГ/					3,200.0	

4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 19. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцах албан тушаалтан	Тайлбар
		2026 он				
		I	II	III		
1	2	3	4	5	6	7
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нийт ажилтны сургалтыг 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	Тохиролцох				АЛТАЙ РЕСОУРСЕС ХХК	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, Хан-Уул дүүргийн Засаг даргатай байгуулсан газар ашиглалтын гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд төвлөрүүлэх	Гэрээнд заасны дагуу					ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ын хязгаарлалтын бүсэд газар ашиглах гэрээ
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал					Тухай бүр	

4.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 20. БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов / он.сар/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	6	7
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОУАӨЯ	Цахимаар /Eic.mn/	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулж, батлуулах	Жил бүрийн 12-р сарын 31-ны дотор	“АЛТАЙ РЕСОУРСЕС” ХХК	Цахимаар /Eic.mn/
		Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хүргүүлж, хянуулах			
Нийслэлийн Байгаль орчны газар	Цахимаар /Eic.mn/ болон 1 хэвлэмэл хувь	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дүгнүүлэх	Жил бүрийн 11-р сарын 01-ний дотор		БОМТ-ний биелэлтийг дүгнэх ажлыг хэсэг төслийн талбайд ажиллана.
Нөлөөллийн бүсийн оршин суугчид, Налайх дүүргийн 6-р хороо, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ын хамгаалалтын захиргаа болон холбогдох оролцогч талууд	Уулзалт, танилцуулга, санал хүсэлт авах хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, ОХШХ-ийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, санал хүсэлт авах	Жил бүрийн 11-р сарын 01-ний дотор		Төслийн талбай, Хан-Уул дүүргийн 8-р хороо, шаардлагатай тохиолдолд цахимаар

БҮЛЭГ 5. ХАВСРАЛТ

1. Хавсралт №1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Хавсралт №2. Газар ашиглах гэрчилгээ
3. Хавсралт №3. Газрын байршлын кадастрын зураг
4. Хавсралт №4. Горхи-тэрэлжийн бцг-ын хязгаарлалтын бүсэд газар ашиглах гэрээ
5. Хавсралт №5. Хог хаягдлын гэрээ
6. Хавсралт №6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй тухай албан бичиг
7. Хавсралт №7. Усны дүгнэлт